

## **De Evenaar, Centrum voor Transculturele Psychiatrie**

Эмчилгээнүүд ба үйл ажиллагаанууд

Экватор [De Evenaar]

Хойд Голландын ёс суртахууны өөрчлөлт ба сэтгэц мэдрэлийн төв

Эмчилгээнүүд ба Чөлөөт цагаа зөв өнгөрөөх эмчилгээ  
Ёс суртахууны өөрчлөлт ба Сэтгэц мэдрэлийн Экватор Төв нь сэтгэл мэдрэлийн өвчтэй ба түүнээс гадна ёс заншил зөрөөнөөс болж сэтгэцийн өөрчлөлтөнд орсон болон хүнд зовлон туулж байснаасаа болж сэтгэлийн өвчинд нэрвэгдсэн гадаад улсаас гаралтай хүмүүст сэтгэл зүйн ба сэтгэл мэдрэлийн эмчилгээ хийх ба тусламж үзүүлдэг.

Та энэ мэдээллийн хуудаснаас Экваторт хийгдэж буй эмчилгээнд орох төрөл бүрийн засал эмчилгээнүүд ба үйл ажиллагаануудын талаар дэлгэрүүлж унших болно. Та энэ мэдээллийн хуудаснаас Экваторт хийгдэж буй эмчилгээнд орох төрөл бүрийн засал эмчилгээнүүд ба үйл ажиллагаануудын талаар дэлгэрүүлж унших болно.

### Чөлөөт цагаа зөв өнгөрөөх эмчилгээ

Энэ засал эмчилгээний явцад цаас, давуу, мод гэх зэргээр төрөл бүрийн материалыг ашигладаг. “Юм хийх” нь анхаарлаа өөр зүйлд төвлөрүүлэхэд сайнаар нөлөөлдөг. Чөлөөт цагаа зөв өнгөрөөх эмчилгээ нь юманд анхаарлаа төвлөрүүлэх болон өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлдэг. Мөн өдрийг яаж өнгөрөөх талаар (сайн дурын) ажил юмуу сургууль курст явах асуудалд анхаарал тавьдаг.

### Чөлөөт сэтгэн бодох эмчилгээ

Энэ нь сэтгэлдээ мэдэрч буй зүйлээ ярихгүйгээр үйл хөдлөлөөрөө гаргах эмчилгээ юм. Энэ эмчилгээ нь хоёр янзаар явагддаг:

- *Дүрслэлийн эмчилгээ*  
Энэ эмчилгээний явцад будаг, харандаа, цаас баримлын шавар гэх мэт зураг, уран бүтээл хийхэд хэрэглэж болохуйц төрөл бүрийн материалыг ашиглан тухайн хүн сэтгэлдээ буй чухал зүйлээ дүрслэн гаргадаг. Ингэж уйтгар гуниг, баяр баясгалан гэх мэт сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлж болдог.
- *Жүжгэн эмчилгээ*  
Энэ эмчилгээнд театр болон жүжиг тоглохтой холбоотой бүх зүйлийг хэрэглэдэг. Жишээлбэл жүжгийн дүр авч тоглох мөн жүжгийн үгнүүдийг өөрөө зохиох, дүрдээ таарсан хувцас өөрөө хийх юмуу нүүрээ будах, маск хийх гэх мэт. Энэ маягаар тохиолдсон зүйлийнхээ талаар ярих шаардлагагүйгээр сэтгэлийнхээ хөдөлгөөнөө илэрхийлж, мэдэж, мэдрүүлж чадна.

### Хүн ба Соёл урлагийн эмчилгээ

Энэ нь хэсэг хүмүүс цугларан соёл урлагийг гол сэдвээ болгон ярилцдаг. Энэ эмчилгээ нь Голландын соёл урлагийг ойлгоход туслах юм. Өөр нэг яригдах зүйл нь өөрийнхөө улсын соёл урлагт байдаг сайн зүйлүүдийн талаар ярилцан, тунгаан бодох нь чухал.

### Эмэн эмчилгээ

Экваторт ихэнхдээ эмний эмчилгээг бас явуулдаг. Эмийн жорыг сэтгэл мэдрэлийн эмч бичиж өгдөг. Эмээ та өөрийнхөө эмийн сангаас авах ёстой.

### Модуль Бие ба Сэтгэлийн дарамт

Шаардагатай тохиолдолд энэ эмчилгээг удаан хугацаагаар сэтгэл санааний дарамтанд орсноос болж биеийн эсэргүүцэл нь их доройтон биеийн зовиур ихтэй болсон хүмүүст өгдөг. Энэ Бие мах боди ба Сэтгэлийн дарамт модульд ерөнхий биеийн эсэргүүцлийг сайжруулах мөн сэтгэлийн дарамтнаас болон үүсдэг биеийн зовиурыг тогтоож мэдэх талаар заадаг.

### Голланд хэл

Шаардлагатай нөхцөлд “GGZ Drenthe”-ийн хэлний багшаас Голланд хэлний хичээл авч болдог. Жишээ нь нэг өвчтөний Голланд хэлний түвшин дэндүү багаас болж эмчилгээгээ хангалттай ойлгохгүй байгаа нөхцөлд.

### Мэдрэлд нөлөөлөхүйц биеийн хөдөлгөөний эмчилгээ (PMT)

Энэ эмчилгээ нь мэдрэлд нөлөө бүхий биеийн хөдөлгөөн хийх ба үүнийгээ мэдрэхэд чиглэсэн. PMT нь биеийн тамирийн зааланд болдог. Хэрвээ удаан хугацаагаар хөдөлгөөн багатай байсан юмуу бүр хөдөлгөөнгүй байсан бол (дахин) хөдлөх нь тааламжтай байх болон сэтгэлийг тайвшруулж болдог. Биеийн тамирийн хувцас болон биеийн тамирын гутал өмсвөл тохиромжтой.

### Сэтгэц ба Биеийн сургалт

Сэтгэл мэдрэл ба биеэн дэх зовиурууд болон тэдний хоорондын уялдаа холбооны талаарх мэдээллийг энэ Сэтгэц ба Биеийн Сургалтанд өгөх болно. Энэ эмчилгээнд нойр, сэтгэлийн хямрал, сэтгэлээ тайван болгох, сэтгэлийг цочроосон явдал, сэтгэлийн хөдөлгөөний талаарх сэдвүүд яригдах болно.

### Сэтгэц мэдрэлийн эмчилгээ / Ярилцлага эмчилгээ

Шаардлагатай нөхцөлд сэтгэц мэдрэлийн эмчилгээг сэтгэл мэдрэлийн эмч юмуу сэтгэл зүйч явуулдаг. Эхний үед ганцаарчилсан байх ба хэд хэдэн төрлийн ярилцлага эмчилгээг үүнд хэрэглэх болно.

### Харилцааны эмчилгээ

Харилцааны эмчилгээнд зөхөн өвчтөнд өөрт нь анхаарал хандуулаад зогсохгүй түүний ар гэрийнхэнд нь анхаарал хандуулах ба мөн тэдний хоорондын харьцаанд анхаарал хандуулдаг. Хэрвээ гэр бүлийн нэг гишүүн өвдвөл бусад нь бас үүнээс болж шаналдаг. Хамтадаа бие биеэндээ дэмжлэг үзүүлж болох зүйлийг хайн олж ингэснээрээ бүгдээрээ энэ асуудалтай харьцаж чадах хүч тэнхээ ихтэй болдог.

### Явцын дунд хариуцах

Эмчилгээ эхлэх үеээс өөрийнхөө амьдарч буй газартаа явагдах үйл ажиллагаатайгаа, эмчилгээтэйгээ танилцаж болно. Одоо явагдаж буй өдрийн хийдэг зүйлдээ өвчтний сэтгэл хэр хангалуун байна гэдгийг явцын дунд ярилцан танилцна. Урдны эзэмшсэн мэргэжил, чадвар болон хүчтэй ба сул талуудыг нь харгалзан үзсний дараа ямар зүйлийг хийж чадахыг тооцоолон гаргадаг. Үүний дараа хүмүүсээ удирдан, гадны туслах байгууллагуудтай, жишээ нь буцаж нийгэмдээ ороход тусладаг байгууллага, “Emplooi” нийгэмлэг (цагаач нарт тусалдаг байгууллага) юмуу нийгмийн соёлын ажилтантай хамтран ажиллаж болно.

**GGZ Drenthe**

De Evenaar (Экватор)

Altingerweg 1

9411 RA Beilen

Шуудангийн хайрцаг 30000

9410 RA Beilen

Утас (0593) 53 58 42

Факс (0593) 53 58 51

E-mail: [deevenaar@ggzdrenthe.nl](mailto:deevenaar@ggzdrenthe.nl)

Экватор нь Weijerd байранд байдаг. Анх ирж байгаа үйлчлүүлэгчид нь үүний хажууханд байгаа Etstoel байрны гол хаалгаар ороод нарийн бичгийн даргат бүртгүүлэх хэрэгтэй.

[www.ggzdrenthe.nl](http://www.ggzdrenthe.nl)

GGZ Drenthe юу хийдэг вэ?

GGZ Drenthe нь сэтгэл мэдрэлийн өвчтнийг эмнэлэгт хэвтүүлж юмуу эмнэлэгт хэвтүүлэхгүйгээр эмчлэх юмуу газар дээр нь эмчилгээ хийдэг. Энэ сэтгэл мэдрэлийн өвчнийг эмчлэх эрүүл мэндийн төв нь 3 хэсэгт хуваагдан ажилладаг: Хойд- Дрэнтэ, Зүүн урд Дрэнтэ мөн Баруун урд Дрэнтэ. Түүнээс гадна GGZ Drenthe нь шүүх шинжилгээний хүрээнд хэвтүүлэх юмуу газар дээр нь тусламж үзүүлдэг.

Өндөр настангуудыг асарч сувилахдаа хоёр асрамжийн газар болон хоёр сувилгааны газарт явуулдаг.

Урьдчилан сэргийлэх, иргэдэд эмчилгээ хийх мөн эрдэм шинжилгээний хүрээнд судалгаа явуулах, эдгээр зүйлүүд GGZ Drenthe-ийн гол ажиллагаа юм. GGZ Drenthe нь олон төрлийн сургалтуудыг явуулдаг жишээ нь сэтгэл мэдрэлийн эмч, эрүүл мэндийн сэтгэл зүйч, эмнэлгийн сэтгэл зүйч, сувилагч, асрагч гэх мэт.

GGZ Drenthe-д ойролцоогоор 3000 хүмүүс ажилладаг ба эдгээр нь Дрэнтэ мужид байдаг арав гаруй төвүүдэд ажилладаг. Жил болгон 15000 хүн бид нараас тусламж хүсэн ирдэг.

© 2006 GGZ Drenthe, Ассэн, НЛ

ZW.025P (11/06)

GGZ Drenthe нь энд бичигдсэн ба зурсан бүх зүйлд зохиолчийн эрхийг эдлэх ба энэ нь хуулийн дагуу хамгаалагдсан. GGZ Drenthe-ээс бичгээр, албан ёсны зөвшөөрөл авсаны дараа энд бичигдсэн зүйлийг хэсэгчлэн юмуу бүхлээр нь хувилж авч ашиглаж болно. Энэ талаар тодруулахыг хүсвэл Харьцаа Холбооны тасагтай холбоо барина уу.